

Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2023 оны ... дугаар сарын ... -ны  
өдрийн ..... дугаар тушаалын  
хавсралт

## **ОЛОН НИЙТИЙН БАЙЦААГЧИЙН АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан нийтийн хэв журмыг сахиулах олон нийтийн байцаагчийн удирдлага, зохион байгуулалт, тавигдах шаардлага, чиг үүргээ хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулна.

1.2.Олон нийтийн байцаагч нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд сайн дурын үндсэн дээр ажиллах хүсэлтэй, сургалтад хамрагдсан, тавигдах шаардлагад нийцсэн, насанд хүрсэн, тухайн орон нутгийн оршин суугч иргэн байна.

1.3.Олон нийтийн байцаагчаар хууль тогтоомж, гэрээгээр хүлээлгэснээс бусад ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

1.4.Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаа, урамшуулах зардлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлнэ.

### **Хоёр.Олон нийтийн байцаагчийн удирдлага, зохион байгуулалт**

2.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүн амын нягтрал, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, онцлогийг харгалзан харьяа нутаг дэвсгэртээ ажиллах олон нийтийн байцаагчийн тоог тогтоож, сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг төрийн бус байгууллага, баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн томилон ажиллуулна.

2.2.Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журмыг орон нутгийн онцлогтоо нийцүүлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

2.3.Цагдаагийн байгууллага нь олон нийтийн байцаагчийг сургалтад хамруулж, үйл ажиллагааг нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

2.4.Сургалт нь үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай эрх зүйн мэдлэг ойлголт болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, мэдээллийг хэрхэн хүлээн авах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаарх мэдлэг ойлголтыг олгоход чиглэгдсэн байна.

2.5.Цагдаагийн байгууллага нь сургалтыг зохион байгуулж хамрагдсан иргэдийн бүртгэл, мэдээллийг сум, дүүргийн Засаг даргад тухай бүр нь хүргүүлнэ.

2.6.Сум, дүүргийн Засаг дарга дараа онд ажиллуулах олон нийтийн байцаагчийн орон тоо, шаардагдах төсвийн саналыг сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж, төсөвт тусгаж, батлуулна.

2.7.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяа нутаг дэвсгэртээ ажиллах олон нийтийн байцаагчийн тоог тогтоохдоо сум, хороо бүр нэгээс доошгүй олон нийтийн байцаагч ажиллуулах зарчмыг баримтална.

### **Гурав.Олон нийтийн байцаагчид тавигдах шаардлага**

3.1.Олон нийтийн байцаагчаар дараах шаардлага хангасан хүнийг сонгон шалгаруулж, томилно.

3.1.1.бүрэн бус дунд ба түүнээс дээш боловсролтой;

3.1.2.эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн байх;

3.1.3.энэ журмын 4.4-д заасан сургалтад хамрагдаж, өөрийн биеэр хүсэлт гаргасан;

3.1.4.насанд хүрсэн, тухайн сум, дүүргийн оршин суугч байх.

### **Дөрөв.Сургалт**

4.1. Цагдаагийн төв байгууллага олон нийтийн байцаагчийг сургаж, дадлагажуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтыг жил болгоны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулна.

4.2.Сургалтын мэдээллийг иргэд олон нийтэд 30-аас доошгүй хоногийн өмнө нээлттэй мэдээллэж бүртгэл явуулна.

4.3.Цагдаагийн байгууллага нь олон нийтийн байцаагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дагнасан, мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг нутгийн өөрөө удирдах байгууллага, нэгж дэх төрийн удирдлагын байгууллагууд болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

4.4.Олон нийтийн байцаагчаар ажиллах иргэнд дараах чиглэлээр сургалтыг зохион байгуулна.

4.4.1.хууль, эрх зүй, хүний эрхийн мэдлэг олгох;

4.4.2.харилцааны соёл;

4.4.3.техник, хэрэгсэл ашиглах;

4.4.4.бусад шаардлагатай дагнасан сургалт.

### **Тав.Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааний чиглэл**

5.1.Олон нийтийн байцаагч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулахдаа бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироохгүй, өөрийгөө аюултай нөхцөл байдалд оруулахгүй, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүйгээр нийтийн ашиг сонирхол, хууль тогтоомжид нийцүүлэн дараах үйл ажиллагааны чиглэлийг баримтална. Үүнд:

5.1.1.сургалтаас авсан мэдээллийн дагуу хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх;

5.1.2. нийтийн хэв журмыг сахиулах, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

5.1.3.хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

5.1.4.нийтийн хэв журам сахих, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, хууль бус үйлдлээ зогсоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах зорилгоор бусдаас шаардах, иргэний бичиг баримт шалгах;

5.1.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй болон үйлдэгдэж байгаа нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад дуудлага мэдээлэл өгөх;

5.1.6.эрсдэл бүхий орчны талаар хариуцах болон холбогдох байгууллага албан тушаалтанд мэдэгдэх, шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар санал гаргах, шаардлага тавих;

5.1.7.гэмт халдлага, эрсдэл, аюул, ослоос өөрийн болон бусдын амь нас, эд хөрөнгө, эрүүл мэндийг хамгаалах шаардлагатай холбогдох арга хэмжээ авах;

5.1.8.олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах талаар санал дэвшүүлэх;

5.1.9.таних тэмдэг бүхий өмсгөл, үнэмлэх, харилцаа холбооны хэрэгслийг зөвхөн гэрээний хугацаанд албан үүргээ гүйцэтгэх үед хэрэглэх;

5.1.10.гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар асуумж, судалгаа мэдээлэл цуглуулж холбогдох байгууллагад мэдээллэх;

5.1.11.хууль болон гэрээгээр хүлээсэн бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

### **Зургаа.Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

6.1.Олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд дараах зарчимуудыг баримтлан ажиллана.Үүнд:

6.1.1.ажил, үүргээ гүйцэтгэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй байх;

6.1.2.ажил, үүргээ гүйцэтгэх явцад аливаа нэг нам, эвсэл, холбооны үйл ажиллагааг дэмжсэн, сурталчилсан үйл ажиллагаа явуулахгүй байх;

6.1.3.ажил, үүргээ биелүүлсэнтэйгээ холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс шан харамж, хандив, тусламж авах, өгөхийг шаардахгүй байх;

6.1.4.ажил, үүргээ гүйцэтгэхдээ согтуурах, мансууруулах бодис хэрэглэх, ажлын байраа дур мэдэн орхиж явах, хууль, журам, гэрээнд заагдсанаас өөр ажил үүрэг гүйцэтгэхгүй байх;

6.1.5.үүрэг гүйцэтгэхээс бусад үед техник, хэрэгслээ биедээ авч явах, хэрэглэх, бусдад шилжүүлэх, хараа хяналтгүй орхихгүй байх;

6.1.6.үүрэг гүйцэтгэж байхдаа олон нийтийн газар, үйлчилгээний газарт тамхи татах, зохисгүй үйлдэл гаргахгүй байх;

6.1.7.иргэд олон нийттэй харилцахдаа харилцаа, хандлагын алдаа гаргахгүй байх;

6.1.8.албан үүргээ гүйцэтгэхдээ олж авсан иргэн, хуулийн этгээдийн хувийн болон бизнесийн нууцтай холбоотой баримт, мэдээллийн талаар бусдад задруулах, тарааж дэлгэрүүлэх, урвуулан ашиглах, олон нийтийн сүлжээнд байршуулахгүй байх;

6.1.9.ажил, үүрэгт холбогдох мэдээллийг нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх буюу удирдлагаас шийдвэр гаргахад аливаа байдлаар саад учруулж, цаг алдагдуулахгүй байх.

### **Долоо.Бусад**

7.1.Олон нийтийн байцаагч нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгаагаар хангагдана.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн олон нийтийн байцаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ**

2023 оны . . . дугаар  
сарын . . . . -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Нийтлэг журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Олон нийтийн байцаагчийн ажиллах нийтлэг журам”-ыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба (Л.Нямгэрэл)-д даалгасугай.

**Х.НЯМБААТАР**